



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/254

Улаанбаатар хот

Г Коронавируст халдвар(COVID-2019)-ын Г  
эмчилгээ болон хавдрын тусламж үйлчилгээнд  
шаардлагатай зарим нэрийн эмэнд импортын  
лиценз олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг сунгах тухай” Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоолын 1 дэх заалт, Хүний эмийн зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвд импортын лиценз олгох эмийг нэгдүгээр, Монгол эм импекс концерн ХХК-д импортын лиценз олгох эмийг хоёрдугаар, Цомбо ХХК-д импортын лиценз олгох эмийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бодлогоор бүртгэх эмийн бүртгэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.

3. Импортолсон эмийн чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, импортлох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллах, эмийн сан, эрүүл мэндийн байгууллагыг эмээр тасралтгүй, жигд хангаж, зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байхыг эм ханган нийлүүлэх байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Н.Гэрэлт-Од/-т даалгасугай.

САЙД  Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 4/154 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД  
ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЭМИЙН ЖАГСААЛТ

Д.д	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Тоо Хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр
1	Авиган /Фавипиравир/	200мг №100	Шахмал	450 хайрцаг	"Fujifilm Toyama Chemical", Япон

Эрүүл мэндийн сайдын 2020 оны...  
дүгээр сарын 20-ны өдрийн...  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



МОНГОЛ ЭМ ИМПЕКС КОНЦЕРН ХХК-Д  
ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЭМИЙН ЖАГСААЛТ

д/д	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр
1	Арбидол /Умифеновир/	100мг №12	капсул	2 500 хайрцаг	Shijiazhuang №4 Pharmaceuticals Co.Ltd, БНХАУ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/254 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ЦОМБО ХХК-Д ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ  
ЭМИЙН ЖАГСААЛТ

д/д	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр
1.	Метотекс /Метотрексат/	50мг-2мл	тарилгын уусмал	2000 фл	"Getwell Pharm", БНЭУ
2.	Метотекс /Метотрексат/	1000мг-40мл	тарилгын уусмал	50 фл	"Getwell Pharm", БНЭУ
3.	Цитовелл /Цитарабин	100мг-1 мл	тарилгын уусмал	500 фл	"Getwell Pharm", БНЭУ
4.	Цитовелл /Цитарабин/	500мг-5 мл	тарилгын уусмал	150 фл	"Getwell Pharm", БНЭУ
5.	Цитовелл /Цитарабин/	1000мг-10мл	тарилгын уусмал	800 фл	"Getwell Pharm", БНЭУ
6.	Дакарб /Дакарбазин/	200мг	липолизид тарилгын нунтаг	200 фл	"Getwell Pharm", БНЭУ
7.	Винбластин сульфат /Винбластин/	10мг-10мл	тарилгын уусмал	50 фл	"Neon Laboratories", БНЭУ
8.	Нитрол /Митаксантрант/	20мг-10мл	тарилгын уусмал	50 фл	"Neon Laboratories", БНЭУ